МЭДЭЭ · 2019 оны 12-р сарын 17

ХОРИХ АНГИЙН АЛБА ХААГЧДАД "ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ" СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Говьсүмбэр аймгийн прокурорын газраас хяналтын харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар Хорих 425 дугаар нээлтэй хорих ангийн алба хаагч нарт "Эрүү шүүлт тулгахаас урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан байна.




Сургалтаар “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц” болон Эрүүгийн хуулийн 13.9 дүгээр зүйлд заасан “Хууль бусаар баривчлах, саатуулах”, мөн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн талаарх ойлголтыг өгчээ.

Мөн прокурор хуульд заасны дагуу цагдан хоригдсон, ял эдэлж байгаа хоригдлын ахуй нөхцөлийг шалгах, тэдгээрээс ирүүлсэн гомдол хүсэлтийг тусгай хайрцагаар хүлээн авч, зөрчигдсөн эрхийг сэргээх, хорих байрны нөхцөлийг сайжруулах талаар холбогдох газар шаардлага, санал хүргүүлэх, хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцуулах зэргээр ял эдлүүлэх ажиллагаанд хэрхэн хяналт тавьж ажилладаг талаар танилцуулж, холбогдох гарын авлага, материалыг тараасан байна.

ЭРҮҮДЭН ШҮҮЛТ ГЭЖ ЮУ ВЭ ?

Эрүүдэн шүүх гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдэж сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ.

/Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг/




Эрүү шүүлтийн шинж тэмдгүүд

- ◊ Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгддэг.
- ◊ Мэдүүлэг, мэдээ сэлт авах зорилготой
  - өөрийнх нь үйлдсэн, эсхүл үйлдээгүй
  - бусдын үйлдсэн гэмт хэргийн талаар
- ◊ Хүссэн зорилгодоо хүрэхийн тулд
  - албадах, хүч хэрэглэх, айлгах, тулгаж хэрэг хүлээлгэх зэрэг хууль бус аргуудыг хэрэглэдэг
- ◊ Эрүү шүүлт бие махбодын, сэтгэл санааны гэсэн 2 хэлбэртэй

ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ ГЭМТ ХЭРГИЙН НОТЛОХ БАРИМТ

Эрүү шүүлт тулгах замаар цуглуулсан, бэхжүүлсэн болох нь тогтоогдсон мэдээ сэлт, мэдүүлэг болон бусад баримтыг эрүү шүүлтэд өртсөн хүн яллагдаж байгаа этгээдийн эсрэг шүүн таслах ажиллагаанд нотлох баримт болгон ашиглаж болохгүй.

Эрүү шүүлт тулгаж цуглуулсан баримт нь зөвхөн эрүү шүүлт тулгасан гэмт хэргийн нотлох баримт болно.



ЭРҮҮГИЙН ХУУЛИАС:

13.9 дүгээр зүйл.Хууль бусаар баривчлах, саатуулах

1.Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг өс хонзон, шунахай, хувийн сэдэлттэйгээр үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах

1. Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

21.13 дугаар зүйл.Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих

1.Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гүйцэтгэх ажлын тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.




Эрх бүхий албан тушаалтнууд нь дараах сэдвүүдээр сургалтанд хамрагдаж анхаарч ажиллах. Үүнд:

1. “Гэрч хохирогч, сэжигтэн яллагдагчтай харилцах ажиллагаа анхаарах асуудал”
2. “Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах”
3. “Зөрчил гаргасан, саатуулагдсан иргэдтэй харилцах, үйлчилгээ үзүүлэхэд анхаарах асуудал”
4. “Зөрчилдөөний шийдвэрлэх арга тактик”
5. “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагч нарын эрхийг хангах нь”

“Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.”

/Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг/



“Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй.”

/Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 14дүгээр зүйлийн 1 дэх хэсэг /



Хаяг, байршил:

Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, Нутгийн удирдлагын ордон, 4-н давхар Говьсүмбэр аймгийн Прокурорын газар

Харилцах утас: (976) - 7054-3092

Факс: (976) - 7054-3141

Цахим шуудан : govisumber@prokuror.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ

2019 он

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2920